

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙН 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ ҮР ДҮНГИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
2.5.1	Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ сайжруулсан байна.	-	-	-	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийг 77%, Чихрийн шижингийн эрт илрүүлгийг 66.8%-д хүргэсэн.	Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх үзлэгийн хамраглалтыг нэмэгдүүлж эрт үед нь эмчилсэн байна.	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийг 80%, Чихрийн шижингийн эрт илрүүлгийг 72.0%-д хүргэнэ.	-	Нийслэлийн төсөв 50,0 сая	Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/12 дугаар тушаалын дагуу Зонхилон тохиолдох үндсэн 4 халдварт бус өвчний илрүүлэгт иргэдийг хамруулах ажлын зохион байгуулж байна. 2025 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар илрүүлгийн үзлэгт давхардсан тоогоор 1,682,009 иргэн хамрагдахаас 1,163,398 иргэн хамрагдаж, эрт илрүүлгийн хамраглалт 69,2%-тай байна. Тодруулбал: 1.Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт 1,027,326 иргэн хамрагдахаас 657773 (64%) иргэн хамрагдаж, 2751 онош батлагдсан тохиолдлыг шинээр хяналтад авч, эмийн эмчилгээг хийж гүйцэтгэсэн байна. 2."Чихрийн шижин хэвшинж 2"-ын эрт илрүүлгийн үзлэгт 654,683 иргэн хамрагдахаас 505625 (77.2%) иргэн хамрагдаж, чихрийн шижин оношлогдсон 928 иргэн хяналтад авсан. 3.Умайн хүзүүний эрт илрүүлгийн шинжилгээнд хамрагдах зорилтот насны 126,635 эмэгтэй хамрагдахаас 32,530	70%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										буюу 21.2% хамрагдсан. Үр дүнгийн үзүүлэлтээр нийт эсийн шинжилгээний 2.8 хувь нь 850 нь Пап эерэг буюу эсийн түвшинд өөрчлөлттэй гарснаас хорт хавдрын шинэ 5 тохиолдол бүртгэгдэж, дараагийн шатны эрүүл мэндийн байгууллагад илгээн эмчилгээнд хамруулж байна. 4.Хөхний эрт илрүүлгийн үзлэгт 358,662 эмэгтэй хамрагдахаас 70.7% буюу 253,483 эмэгтэй хамрагдсан. Үүнээс 144 (0,1%) тохиолдол хөхний эмнэлзүйн үзлэгээр эерэг илэрсэн ч хорт хавдрын шинэ өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. 5Элэгний хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт 135,643 иргэн хамрагдаж, 44 хорт хавдрын тохиолдлыг оношилсон.	
2.5.2	Дүүрэг бүрт эрэгтэйчүүдийн кабинет байгуулна.	-	-	-	0	Байгуулсан эрэгтэйчүүдийн кабинетын тоо	8	-	-	Нийслэлийн хэмжээнд нийт 10 эрэгтэйчүүдийн кабинет ажиллаж байна. Үүнд: Долоон дүүргийн Эрүүл мэндийн төв, 3 нэгдсэн эмнэлэг /БНДЭМТ, БГДЭМТ, БЗДЭМТ, ХУДЭМТ, НДЭМТ, ЧДЭМТ, СБДЭМТ, ХУНЭ, СБНЭ, СХНЭ-2025 онд/ эрэгтэйчүүдийн болон урологийн кабинетыг байгуулж, тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Дээрх байгууллагууд эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 тушаалын 3 дугаар хавсралтад заасан кабинетад	100%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр хангагдсан.	
2.5.3	Эрүүл мэндийг дэмжих төвийг дүүрэгт байгуулна. 8	-	-	-	0	Эрүүл мэндийг дэмжих төвийн тоо	8	-	-	Нийслэлийн хэмжээнд нийт 7 /ХУДЭМТ, БЗДЭМТ, ЧДЭМТ, СХДЭМТ, СХНЭ, ХУНЭ, Амгалан амаржих газар/ байгууллагад эрүүл мэндийг дэмжих төвийг шинээр байгуулан ажиллаж байна. Эдгээр төвөөр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоог зохион байгуулан ажиллаж байна.	88%
2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.											
2.6.1	БЗДХ/ДОХ,С үрьеэ, халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж эмчилгээнд бүрэн хамруулсан байна.	-	-	-	10,000 хүн амд ногдох тоо БЗДХ өвчний тохиолдол 55.4, сүрьеэ өвчний тохиолдол 14.7, В гепатитын	Эрт илрүүлгийн хувь, хавьтал илрүүлэлтийн хувь, эмчилгээнд хамрагдах хувь	10,000 хүн амд ногдох тоо БЗДХ өвчний тохиолдол 50.0, сүрьеэ өвчний тохиолдол 12.4, В гепатитын тохиолдол 6	-	Нийслэлийн төсөв 50,0 сая	Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 10 сарын байдлаар БЗДХ өвчний тохиолдол 30.6, сүрьеэ өвчний тохиолдол 6.2, В гепатитын тохиолдол 0.22 байна. Тайлант хугацаанд халдварт өвчний 32,191 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 194 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 15,919 тохиолдол буюу 49.4%-иар нэмэгдсэн байна. Бэлгийн замаар дамжих халдварт өвчнийг илрүүлэх үзлэг, шинжилгээ, хавьтал илрүүлгийг нэмэгдүүлэн ажиллаж байна. Зонхилон тохиолдох БЗДХ-ын 5,074 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 15.76%-ийг эзэлж байна. Үүнээс,	100%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
					тохиолд ол 8					27.3% заг хүйтэн, 46% тэмбүү, 26% трихомониаз, 0.67 ХДХВ/ДОХ байна. Төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 2025 онд 12 бүртгэгдсэн байна. БЗДХ өвчний эмчилгээнд нийт 4,811 хүн хамруулж, эмчилгээний амжилт 94.8%-тай байна. Нийслэлийн 9 дүүргийн сүрьеэгийн кабинетад нийт 79,946 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 47,968 буюу 60.2%-тай байна. Сүрьеэгийн 1,022 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба 10,000 хүн амд 6.2 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 56 тохиолдлоор (0.5 промилль) буурсан байна. Нийт тохиолдлын 99%-ийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний амжилт 79.9%-тай байна. Тайлант хугацаанд Вируст гепатит өвчний 130 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 0.78 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20 тохиолдол буюу 0.1%-иар нэмэгдсэн. Вируст гепатитын тохиолдлын 28.4%-ийг эзэлж буй "Вируст гепатит В"-ийн 37 тохиолдол (0.22 промилль) бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор нэмэгдсэн байна. "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр" буюу 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийг батлагдсан төлөвлөгөөний дагуу 13 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж, тайланг 2025 оны 04 дүгээр	

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										сарын 01-ний өдөр ХӨСҮТ, ЭМЯ-д хүргүүлсэн. Налайх, Сүхбаатар, Баянгол дүүргийн хороодын нийгмийн ажилтан, ЕБС, их дээд сургуулийн эмч, нийгмийн ажилтнуудад “Өсвөр үеийнхний дунд тохиолдол БЗДХ” сэдвээр 3 удаагийн нөлөөллийн уулзалт зохион байгуулсан.	
2.6.2	Товлолын дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаас сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдол бууруулсан байна.	-	-	-	95%	Тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний товлотт дархлаажуулалтын хамралтын хувь	98,2%	-	Нийслэлийн төсөв 10,0 сая	Товлолт дархлаажуулалтын хамралтын мэдээг сар бүр тогтмол гарган ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдахаас 384,794 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 97,5% байна. Үүнд: 1.БЦЖ (1 тун) – 99.5% 2.Гепатит В (1 тун) – 99.3% 3.Саа (4 тун) – 95,0% 4.Тавт (3 тун) – 95.5% 5.УГУ (2 тун) – 97,3% 6.Гепатит А (2 тун) – 95.3% 7.Пневмококк (3 тун) – 95.5% 8.Сахуу-татран (2 тун) – 73,3% байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Хүний папиллома вирус (1тун) дархлаажуулалтын хамрагдалт - 47.8%-д хүрсэн. Хүний папиллома вирусын эсрэг вакциныг “Дархлаажуулалтын үндэсний товлот”-д шинээр нэвтрүүлсэнтэй	78%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										холбогдуулан дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1256 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын “Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай” А/168 дугаар тушаал, “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай” А/179 дүгээр тушаалуудыг гарган хэрэгжилтийг хангасан. НЭМГ-ын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар нийслэлийн ЕБС-иудын дунд “Эрүүл чийрэг өсвөр үе” аян, нийслэлийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дунд “Зорилтот насны хүүхдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх аян”-ыг тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд 6 сургууль, 4 ӨЭМТ шалгарч, 3,084 иргэнд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан байна. Мөн НЭМГ-ын даргын 2025 оны “Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай” А/321 дүгээр тушаалын дагуу НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран Нийслэлийн төрийн, хувийн өмчийн сургуулиудын 325	

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										эмч, мэргэжилтэнг сургалтад хамруулсан.	
2.7 Нийгмийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно.											
2.7.1	Дүүрэг бүрт “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулсан байна.	-	-	-	0	Нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо	2/8/	-	Улсын төсөв	Нийслэлийн хэмжээнд 3 нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулсан байна. Багануур дүүрэг Нийгмийн эрүүл мэндийн төвийн тусдаа байртай. Баянзүрх дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгыг улсын төсвийн 3.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2024 онд барьж ашиглалтад оруулсан. Чингэлтэй дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил бүрэн дууссан. ЭМЯ-аас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байгаа тул дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх үйл явц хүлээлтийн байдалтай байна. Дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд Сонгинохайрхан дүүргийн эрүүл мэндийн төвийн барилгыг ашиглалтад оруулсан. Налайх болон Хан-Уул дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах барилгын боломж хомс, Сүхбаатар,	100%

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										Баянгол дүүрэгт зохицуулалт хийх боломжтой.	
2.8.1	Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулна.	НҮБ ХС	-	-	Эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд ногдох тоо 24.3, Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд 89.1%, 1 хүртэлх насны нялхсын эндэгдэл 1,000 хүнд ногдох тоо 12.9, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 хүнд	Эхийн эндэгдэл 100,000 амьд төрөлтөд ногдох тоо 22. Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд 91 %, 1 хүртэлх насны нялхсын эндэгдэл 1,000 хүнд ногдох тоо 11.5, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1,000 хүнд ногдох тоо 12.9		-	-	2025 оны эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж 100,000 амьд төрөлтөд 40.4 байна. Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд буюу жирэмсний эрт хяналт 92.8%. 0-1 насны нялхсын эндэгдэл 1,000 хүнд амд 14.5, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17.2 байна. Эх, хүүхдийн үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагуудад чиглэл өгч тотмол хяналт тавьж ажиллаж байна. Эндэгдлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: 1.Хүүхэд, нярайн эндэгдлийн хожимдол, шалтгааны талаарх хэлэлцүүлгийг 2025 онд хэд хэдэн удаа зохион байгуулсан. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзэхэд 83.9% нь перинаталь үеийн эмгэг, 27,8% нь төрөлхийн гажиг хөгжил, 10,2% нь амьсгалын тогтолцооны өвчний улмаас эндсэн байна. Тиймээс эндэгдлийг бууруулах зорилгоор нийслэлийн 3 амаржих газарт “Эхийн сүүний банк” байгуулж, “Нярайн тархи хөргөөх эмчилгээ”, “Дутуу төрсөн нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр	25%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
					ногдох тоо 14.9					давтамжит аппаратаар удирдах эмчлгээг" тус тус шинээр нэвтрүүлсэн. 2.Жирэмсний эрт хяналтыг сайжруулах, ургийн гажгийг эрт илрүүлэх боломжийг нэмэгдүүлэхээр 2025 оны 06 дугаар сард 8 дүүргийн ЭМТ, 3 амаржих газар болон нийслэлд эх барих, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн 38 эмэгтэйчүүдийн эмнэлгийн төлөөлөл оролцсон хамтарсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. 3.Жирэмсэн эхийн эрэмбэлэн ангилал, яаралтай тусламжийг сайжруулах зорилгоор түргэн тусламжийн эмч нарыг амаржих газарт дадлага сургалтад хамруулсан. 4.Ургийн хромосомын гажиг илрүүлэх шинжилгээг дүүргүүдэд нэвтрүүлэх зорилгоор жирэмсний эхний 3 сарын хэт авиан шинжилгээ хийх чадамжтай албан ёсны сертификаттай 7 эмч бэлтгэсэн. 5.Эхийн эндэгдлийн ноцтой тохиолдол бууруулахаар 2025 оны 02 дугаар сард 01/253 тоот албан бичгээр харьяа байгууллагад чиглэл хүргүүлж, 7 байгууллагын мэс засал, эх барихын 19 эмчийг 3 амаржих газарт ажлын байрны чадавхжуулах сургалтад хамруулсан. 6.Эх барих, эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах	

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										зорилгоор НЭМГ-ын даргын 2025 оны "Аян зохион байгуулах тухай" А/94 дүгээр тушаалаар "Хариуцлагатай сонголт" аяны хүрээнд 18 үйл ажиллагааг зохион байгуулсан. 7.Эхийн эндэгдлийн ноцтой тохиолдол давтан гарахаас сэргийлж тохиолдолд суурилсан хэлэлцүүлгийг танхимаар 2 удаа (нийт 95 оролцогч), цахимаар 4 удаа (нийт 3600 оролцогч) зохион байгуулсан.	
2.9 Гэр бүл төлөвлөлт нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэнэ.											
2.9.1	Өсвөр насны хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлнэ.	-	-	-	26,340	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо Эрүүлжсэн хүүхдийн тоо, хувь	35200	-	Нийслэлийн төсөв 18,0 сая	2025 оны 11 сарын байдлаар нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн кабинетаар болон урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 42,416 хүүхдийг үзлэг хамруулсан байна. Үзлэгийн дүнд 16,028 хүүхдэд эмчилгээ шаардлагатай байгаагаас 14,695 хүүхдийг эмчилгээнд хамруулж, 91.6%-ийг эрүүлжүүлээд байна.	100%
2.9.2	Нөхөн үржихүй насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн жирэмслэх	-	-	-	58.3%	ЖСА-д хамруулсан эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн тоо	Эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдийн 67,9% хамрагдана.	-	Улсын төсөв	Нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төвд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг сайжруулах чиглэл өгч шинэчилсэн. Нийт нөхөн үржихүйн насны 422,442 эмэгтэйчүүдээс 62,268 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар жирэмснээс сэргийлэх арга	95%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
	эс сэргийлэх арга хэрэглэгээг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.									хэрэгслээр 41,987 зорилтот бүлгийн эмэгтэй хангагдаж, хамрагдалт 67,4% байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай" А/770 дүгээр захирамжийг батлуулан ажилласан. 1.Захирамжийн дагуу жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг таниулах хөтөч дэвтрийг боловсруулан 28,000 ширхэгийг гарган 9 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тухай мэдээлэл, сургалтыг үйл ажиллагаанд ашиглаж байна. 2.Оюутны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүсээгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулахад хамтран ажиллах тухай албан бичгийг Боловсролын Ерөнхий газарт хүргүүлэн ажилласан. 11 сарын байдлаар МУБИС, МУИС, ДХИС, ХААИС, ШУТИС, УТИС, Оточ манрамба, МҮИС, ИЗИС, ТЗИС, ҮБХИС, УБЭДС, БТДС, ТТДС, зэрэг 14 их, дээд сургуулийн 14,080 оюутанд нөхөн үржихүйн эрүүл мэндийн	

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Тамгын газруудтай хамтарч, 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан гээд нийт 1,369 албан хаагчдыг хамруулсан.	
2.10 Нийгмийн Эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ											
2.10.1	Шаардлагатай хүний болон, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, бэлэн байдал хангагдсан байна.	-	-	-	Харьяа эрүүл мэндийн 39 байгууллагад 6,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий 131 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмж, 16 байгууллагад 4,6 тэрбум	Хангасан автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тоо, Нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын тоо, Нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн	Нэн шаардлагатай тоног төхөөрөмж эмнэлгийн зориулалттай автомашин хангана. 20 эрүүл мэндийн байгууллагад нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийнэ. Нийслэлийн эрүүл	-	Улсын төсөв, Гадаадын зээл тусламж, Нийслэлийн төсөв-500,0 сая	1.НЭМГ-ын харьяа 27 эрүүл мэндийн байгууллагад 2025 онд нийт 25.3 тэрбум төгрөгөөр нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн зориулалттай автомашинаар хангаж сайжруулсан. 2. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор 2025 онд 27 байгууллагын Улаанбурхан өвчний эсрэг вакцин, Аминдэм, вирусын эсрэг эм, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн. НЭМГ-ын даргын 2025 оны "Шуурхай удирдлагын баг томилох тухай" А/43, "Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах тухай" А/154 дүгээр тушаалыг хэрэгжүүлэн төлөвлөлт, тандалт, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, санхүү, нөөц хангалт, эрсдэлийн харилцаа	100%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
					төгрөгийн өртөг бүхий 40 ширхэг автомашин	йн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургуулилтын тоо	мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургуулилтын 5 удаа хийсэн байна.			зэрэг чиглэлээр шуурхай удирдлагын баг, нэгжүүд ажиллаж, эм эмнэлгийн нөөцийн мэдээг 7-14 хоног тутам авч ажиллаж байна. 3.Нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургуулилт, сургалтыг 5 удаа хийсэн. Үүнд: Шувууны томуугийн халдварын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны чадавхыг сайжруулах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд НЭМГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, НЗӨСҮТ, ХУДЭМТ, ХУДНЭ, Цагдаа, Онцгой, тагнуулын нийт 8 байгууллагын 45 мэргэжилтэнг хамруулсан үзүүлэх сургалтыг хийсэн. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ” сэдэвт 2025 оны 05 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан улсын дадлага сургуулилтад харьяа 9 дүүргийн ЭМТ, түргэн тусламжийн төвийн 27 мэргэжлийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Газар хөдлөлтийн дуут дохио, бэлэн байдлын хангахаар нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага,	

№	Зорилт	Төсөл, арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлагдсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн үнэлгээ
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										сургуулилтын сургалтыг 2 удаа, Улаанбурхан өвчний бэлэн байдал хариу арга хэмжээний сургалтыг 1 удаа хийсэн.	
2.11 Хотын хүн амыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүргэж аюулгүй үр дүнтэй нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган Эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.											
2.11.1	Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	-	-	-	15	Шинээр нэмэгдсэн тусламж, үйлчилгээний нэр төрөл	4 /12/	-	-	Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад 2025 онд 5, 2021-2025 онд нийт 16 нэр төрлийн тусламж, үйлчилгээг шинээр нэвтрүүлснээр тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, хүлээгдэл буурч, иргэдийн сэтгэл ханамж нэмэгдсэн. Тухайлбал: 1.Гурван амаржих газарт “Эрт нярайн тархи хөргөөх эмчилгээ”-г, 2.Өргөө, Амгалан амаржих газарт “Эхийн сүүний банк”-ийг анх удаа, 3.Баянгол дүүргийн ЭМТ-д хавдрын 20 ортой тасгийг шинээр нээж нийслэлийн иргэдэд хавдар, хими, өдрийн эмчилгээг, Сүхбаатар дүүргийн ЭМТ-ийн Сэлбэ нэгдсэн эмнэлэгт 30 ортой хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг тус тус, 4.Нийслэлийн Өргөө амаржих газарт “Дутуу төрсөн нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжаар амьсгал аппаратаар удирдах” эмчилгээг, 5.Баянзүрх нэгдсэн эмнэлэгт CRRT эмчилгээг тус тус шинээр нэвтрүүлсэн.	100%
2.11.2	Стандартын шаардлага хангасан	-	-	-	4	Судалгаа Хүргүүлсэн санал	31	-	Улсын төсөв	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020 онд 6 бие даасан, 1	

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
	Өрхийн Эрүүл мэндийн төвийн тоо нэмэгдүүлж, үйлчилгээни й хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.									цогцолбор, 2022 онд 5 бие даасан, 1 цогцолбор, 2023 онд 4 цогцолбор, 2024 онд 1 бие даасан, 6 цогцолбор нийт 12 бие даасан, 12 цогцолбор ӨЭМТ-ийн барилга, 2025 онд Сонгинохайрхан дүүргийн 42-р хорооны өрхийн эрүүл мэдийн төвийн цогцолбор барилгыг тус тус ашиглалтад оруулаад байна. /Нийт 25/. Улсын төсвийн хөрөнгөөр Багануур дүүргийн 4-р хорооны 1 өрхийн эрүүл мэндийн төв, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүргийн 6, 8, 33, 34, 35, 36, 37, 40-р хороо, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Сүхбаатар дүүргийн 16-р хороо, Баянзүрх дүүргийн 35-р хороо, Баянгол дүүргийн 18-р хороо нийт 13 цогцолбор барилга ашиглалтад орохоор шинээр баригдаж байна. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хооронд байгуулсан гэрээний дагуу хэрэгжиж буй "Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 1-р үе шатанд 4 дүүрэгт жишиг өрхийн эрүүл мэндийн төв барих ажлын барилгын ажлын нийт явц 70% байна. Үүнд: Чингэлтэй дүүргийн 19-р хорооны барилгын ажлын гүйцэтгэл 80%, Сонгинохайрхан дүүргийн 26-р	78%

№	Зорилт	Төс өл, арга хэм жээ	Хэрэгжүү лэх хугацаа	Эх үүсвэр	Суурь түвшин	Шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Батлаг дсан төсөв (сая төгрөг)	Төсвийн гүйцэтгэл (сая төгрөг)	Хэрэгжилтийн явц	Хэрэгж илтийн үнэлгэ э
1	2	3	4	6	7	8	9	10	11	12	13
										хорооны барилгын ажлын гүйцэтгэл 90%, Баянзүрх дүүргийн 17-р хорооны барилгын ажил 30% байна.	
Хэрэгжилтийн дундаж хувь											86.1%

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ТӨЛӨВЛӨГӨӨ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



У.БАТ-ОЧИР /2025.12.01/

Д.ЭНХТҮВШИН /2025.12.01/

ЗАХИРГАА, НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:

М.ХОРОЛСҮРЭН /2025.12.01/

№	Гүйцэтгэлийн хувь	Арга хэмжээ	Ажил үйлчилгээний тоо	Нарийвчилсан үнэлгээ	
1	85-100	8			
2	60-84	3			
3	30-59	0			
4	0-29	1			
	Нийт 12 арга хэмжээ	Хэрэгжилтийн дундаж 86.1%			

НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН
ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН 2025 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
Эрүүл мэнд							
Зорилт 2.5. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй нас баралтын хувийг бууруулна.							
37	2.5.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ сайжирсан байна.	Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин	10,000 хүнд ногдох тоо	15.5	14	13.1	-
38		Амьсгалын замын өвчний шалтгаант нас баралтын түвшин	10,000 хүнд ногдох тоо	2.7	2.1	2.5	Амьсгалын замын өвчний шалтгаант нас баралт сүүлийн жилүүдэд ихсэж байгаа нь агаарын бохирдол, хүн амын дудах тамхидалт зэрэг хүчин зүйлс нөлөөж байна.
39		Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	77.0	80.0	72.7	Тайлан оны 10 сарын байдлаар 72.7% байна. Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийг бүтэн жилийн хугацаанд зохион байгуулдаг ба жилийн эцэст зорилтот түвшинд хүрэх боломжтой.
40		Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	хувь	66.8	72.0	77	-
41	2.5.2. Дүүрэг эрэгтэйчүүдийн бүрд	Байгуулагдсан кабинет	тоо	0	8	9	-

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
	кабинет байгуулагдсан байна.						
42	2.5.3. Эрүүл мэндийг дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулсан байна.	Байгуулагдсан дэмжих төв	тоо	0	8	7	Гүйцэтгэлийн санхүүжилт болон төсөв хүрэлцээгүйн улмаас эрүүл мэндийг дэмжих төвийг үргэлжлүүлэн байгуулах боломжгүй болсон.
Зорилт 2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан өвчлөлийг бууруулна.							
43	2.6.1. БЗДХ/ДОХ, сүрьеэ, халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан байна.	БЗДХ өвчний тохиолдол	10,000 хүнд ногдох тоо	55.4	50.0	30.6	-
44		Сүрьеэ өвчний тохиолдол	10,000 хүнд ногдох тоо	14.7	12.4	6.2	-
45		В гепатитын тохиолдол	1,000 хүнд ногдох тоо	8	6	0.78	-
46.	2.6.2. Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдол буурсан байна.	Вирусны гепатит В өвчний товлотт дархлаажуулалтын хамралтын хувь	хувь	99.6	99.8	99.5	Вируст гепатит В өвчний товлотт дархлаажуулалтыг төрсөн хүүхдэд 24 цагийн дотор төрөх тасагт хийдэг. Хамралтын хувь дутуу байгаа нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн төрөх эмнэлэгт төрсөн хүүхдийн дархлаажуулалтад орсон мэдээлэл дутуу орж ирж байгаатай холбоотой. Цаашид тус мэдээллийн дутуу байдлыг нөхөх зорилгоор ХӨСҮТ-ийн Дархлаажуулалтын албатай нягт хамтарч ажиллаж байна. Тухайлбал 2025 оноос бүх төрөх тасагтай эмнэлэгт төрсөн хүүхэд бүрийн эхний дархлаажуулалтад орсон мэдээллийг заавал хийх дархлаажуулалтын цахим бүртгэлд шинээр үүсгэж байна.

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
47.		Тавт/Халдварт саа өвчний товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	хувь	98	99.0	95.2	Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулалтын дараа хүн амын дунд вакцинд итгэх итгэл буурч, үүнээс шалтгаалан заавал хийх дархлаажуулалтын хамралт эрс буурсан. Иргэдийн дундах дархлаажуулалтын эсрэг бүлэг хүмүүсийн тоо нэмэгдэж байна. үүнтэй холбоотойгоор товлолын дархлаажуулалтад нөлөөлөл нэмэгдэж байна. Тавт/Халдварт саа өвчний товлолт дархлаажуулалтын нийт 6 тун хийгддэг. Дүүргийн Эрүүл мэндийн төв болон Өрх, тосгоны эрүүл мэндийн төвд байрлах дархлаажуулалтын кабинет, нэгжид иргэд хүүхдээ авч ирэн дархлаажуулалтад хамруулдаг. Товлолт хугацаандаа ирж дархлаажуулалтад хамрагдаагүй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч нарыг дуудаж дархлаажуулалт хамруулах ажлыг тогтмол зохион байгуулж байна. Түүнчлэн дархлаажуулалтын ач холбогдлыг таниулах мэдээлэл сурталчилгааны ажлыг нэмэгдүүлж, нөхөн болон нэмэлт дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулж байна.
48.		Улаанбурхан-Гахайн хавдар-Улаанууд өвчний товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	хувь	94.8	96.0	97.3	-
Зорилт 2.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бий болгоно							
49.	2.7.1. Дүүрэг бүрд "Нийгмийн эрүүл	Нийгмийн эрүүл мэндийн төв	тоо	0	8	3	Дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг болгон

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
	мэндийн төв"-ийг байгуулсан байна.						өөрчилж нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр байгуулахаар төлөвлөсөн. Эрүүл мэндийн яамнаас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээлтийн байдалтай байна. Налайх болон Хан-Уул дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах барилгын боломж хомс. Сүхбаатар, Баянгол дүүрэгт зохицуулалт хийх боломжтой.
Зорилт 2.8. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна							
50.	2.8.1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулна.	Эхийн эндэгдэл /амьд төрөлт/	100,000 хүнд ногдох тоо	24.3	22.0	40.4	Эхийн амьдарч буй орчны түвшин, хот ба хөдөөгийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн ялгаа, эхийн нас, боловсролын түвшин, өрхийн орлого, хооллолтын байдал, архи тамхины хэрэглээ зэрэг эрсдэлт хүчин зүйлүүд нь эхийн эндэгдэлд шууд нөлөөлдөг. 2025 онд нийслэлд бүртгэгдсэн эхийн эндэгдлийн тохиолдлуудыг дүгнэхэд, эмнэлгийн бус нөхцөлд эндсэн болон жирэмсний эрт хугацаанд эндсэн тохиолдлууд өмнөх жилтэй харьцуулахад нэмэгдсэн нь анхаарал татаж байна.
51.		Жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	89.1	91.0	92.8	-
52.		Нялхсын эндэгдэл	1,000 хүнд ногдох тоо	12.9	11.5	14.5	Нялхсын эндэгдэл тууштай буурахгүй байхад дараах хүчин зүйлс нөлөөлж байна. Үүнд: 1.Жирэмсэн эхийн эрүүл мэнд, архаг суурь өвчин, хорт зуршил, ажлын нөхцөл байдлаас

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
							үүдэн дутуу төрөлт, перинаталь үеийн эмгэг буурахгүй байна. 2. Түр оршин суугч болон хөдөө орон нутгаас төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлэгт тусламж, үйлчилгээ авч байхдаа нас барсан хүүхдийн тоо суурь түвшингийн оноос хойш 13%-аар нэмэгдсэн. 3.Эрүүл хүүхэд төрөхөд эхийн эрүүл мэндээс гадна нөхрийн эрүүл мэндийн байдал, гэр бүл төлөвлөлт анхаарах асуудал болж байна.
53.		Хүүхдийн эндэгдэл /5 хүртэлх нас/	1,000 хүнд ногдох тоо	14.9	12.9	17.1	Жирэмсэн эхийн перинаталь үеийн халдвар, бөөр шээсний замын халдвар бусад эхийн архаг өвчинтэй холбоотой байхаас гадна жирэмсний хяналтад оройтож орох, иргэдийн шилжилт хөдөлгөөн, түр оршин суугаа газрын эрүүл мэндийн байгууллагад бүртгүүлэхгүй байх, эмнэлгийн тусламжийг хожимдож авах зэрэг шалтгаанууд нөлөөлж байна. Мөн эцэг эхийн хараа хяналт муу байгаа нь осол гэмтлийн тоо нэмэгдэх шалтгаан болж байна.
54.		Тухайн жилийн товлотт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	хувь	95.0	98.0	97.0	Иргэдийн дундах дархлаажуулалтад хүүхдээ хамруулах хандлагатай холбоотой багасч байна.
Зорилт 2.9. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүн бүрд хүргэнэ.							
55.	2.9.1. Өсвөр насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлнэ.	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхэд	тоо	26,340	35,200	41,946	-
56		Өсвөр насны охидын төрөлт	1,000 хүнд ногдох тоо	26.9	25	15.1	-

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
57	2.9.2 Нөхөн үржихүйн насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх арга хэрэглээг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар хангагдсан нөхөн үржихүйн насны (15-49) эмэгтэйчүүдийн эзлэх хувь	хувь	58.3	67.9	67.4	Бүтэн жилийн хугацаанд зохион байгуулдаг арга хэмжээ тул жилийн эцэст зорилтод түвшинд хүрэх боломжтой.
Зорилт 2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ							
58.	2.10.1 Шаардлагатай хүний болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, бэлэн байдал хангагдсан байна.	Нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллага	тоо	1	20	27	2025 онд 27 байгууллагад Улаанбурхан өвчний эсрэг вакцин, А аминдэм, вирусын эсрэг эм, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн. 2021 онд 29, 2022 онд 26, 2023 онд 10, 2024 онд 5, 2025 онд 27 нийт 97 байгууллагын нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн байна.
59.		Нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургууллт	тоо	1	5	5	2025 онд 5 удаагийн сургууллт хийсэн. 2022 онд 1, 2023 онд 3, 2024 онд 1, 2025 онд 5 нийт 10 байгууллагын нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн байна.
Зорилт 2.11. Хотын хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэж, аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.							
60.	2.11.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Нийслэлд эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээг байгуулах	тоо	0	3	2	Нийслэл Улаанбаатар хотыг 14 хот 42 хорооллын болгох төлөвлөлт хэрэгжиж эхлэх үетэй уялдуулан нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээг байгуулна.

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
61.		Хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалд шилжсэн дүүргийн эмнэлэг	тоо	0	8	3	Эрүүл мэндийн яамнаас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээлтийн байдалтай байна.
62.		Шинээр нэмэгдсэн тусламж, үйлчилгээний нэр төрөл	тоо	5	12	16	-
63		Наркологийн эмнэлэг	тоо	1	1	-	Тус барилгын анхны төсөвт өртөг 2022 онд 10.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2024 онд 39.8 тэрбум төгрөг болж нэмэгдсэн болон тайлант хугацаанд санхүүжих төсөв хүрэлцээгүй батлагдаж байгаатай холбоотойгоор барилгын ажлын явц удаашралтай байна.
64		Жишиг нэгдсэн эмнэлэг	тоо	1	4	1	1.Хан-Уул дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга баригдаж байна. Барилгын ажлын явц 40%-тай байна. 2.Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга барихаар төлөвлөсөн талбайн газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна. Дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэвэл барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болно.
65		Тосгоны эрүүл мэндийн төв	тоо	2	3	3	-
66		Нэг эмчид ногдох сувилагч	тоо	0.9	1.4	0.9	Монгол Улсад эмч, сувилагчийн харьцааг 1:2 хүргэх зорилт тавьж, сувилагч бэлтгэх сургалтын төлбөрийг чөлөөлсөн ч Улаанбаатар хотод 2025 оны 10 сарын байдлаар эмч сувилагчийн харьцаа 1:0.9 байна. Үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь сувилагч мэргэжилтний цалин бага, ажлын ачаалал их, мэргэжлийн үнэ цэнэ бага байгаатай холбогдуулан мэргэжил сонголт бага байна.

№	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин 2020	Зорилтот түвшин 2025	Тайлант хугацааны хүрсэн түвшин /2025/	Тайлбар (Зорилтот түвшинд хүрээгүй бол шалтгаан нөхцөлийн тайлбар)
1	2	3	4	5	6	10	11
67.	2.11.2.Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төв	тоо	11	31	25	2025 онд Улсын төсвийн хөрөнгөөр 1 бие даасан өрхийн эрүүл мэндийн төвийн барилга, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 цогцолбор өрхийн эрүүл мэндийн төвийн барилга, Гадаад хандив зээл тусламжаар 4 жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилга нийт 17 өрхийн эрүүл мэндийн төв ашиглалтад орохоор барилга угсралтын ажил үргэлжилж байна.